

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ БАРИХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах, засвар арчлалт хийх, хяналт тавихтай холбоотой байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын хуульд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол хуулийг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журмыг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.4. Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. "Тусгай зориулалтын авто зам" гэж тусгай зориулалтын тээврийн үйлчилгээнд зориулсан авто замыг;

1.4.2. "Тусгай зориулалтын тээврийн үйлчилгээ" гэж тээврийн хэрэгсэлийн бүх жин, нэг тэнхлэг дээрх ачаалал, оворын хэмжээний хувьд "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011 стандартад заасан хязгаараас давсан автомашин болон технологийн авто тээврийн хэрэгслээр ачааг үүсэх цэгээс шингэх цэг хүртэл тогтоосон чиглэл, давтамжтай тээвэрлэлт гүйцэтгэх үйл ажиллагааг;

1.4.3. "Тусгай зориулалтын авто замын эзэмшигч" гэж авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тусгай зориулалтын авто замыг эзэмшиж буй авто замын хөрөнгө оруулагчийг;

1.4.4. "Тусгай зориулалтын авто замын хариуцагч" гэж Авто замын тухай хуулийн 4.1.12-д заасны дагуу захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор засвар, арчлалтын ажлыг тогтмол гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээдийг;

1.4.5. "Роялти" гэж Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж эзэмшиж, авто замын зурвас газар ашигласны төлбөр.

Хоёр. Тусгай зориулалтын авто замын сүлжээг барьж, ашиглахад баримтлах зарчим, ангилал

2.1. Тусгай зориулалтын авто замын сүлжээг хөгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.1.1. Тусгай зориулалтын авто замыг үндэсний авто замын сүлжээний хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, барьж байгуулах, ашиглах;

2.1.2. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг эрх бүхий байгууллагаар батлагдсан стандарт, норм, нормативын дагуу барьж байгуулах;

- 2.1.3. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг барих, эзэмших, ашиглах, арчлах, хамгаалах, засварлах үеийн үйл ажиллагаа нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө бага байх;
- 2.1.4. Тусгай зориулалтын авто замын чиглэлийг сонгохдоо аль болох өмнө баригдсан тусгай зориулалтын авто замуудад холбох боломжийг судлах, олон салаа зам гаргахаас татгалзах;
- 2.1.5. Тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөр хураамж нь авто зам эзэмшигчид ашигтай, авто зам хэрэглэгчид дарамт үүсгэхгүй хэмжээнд байх;
- 2.1.6. Тусгай зориулалтын тээвэрлэлтийг хатуу хучилттай авто зам барьж, хүн, мал амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсний дараа гүйцэтгэх;

2.2. Тусгай зориулалтын авто замыг дараах байдлаар ангилах бөгөөд энэхүү журам нь зөвхөн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай авто замыг барих, ашиглах үед үйлчилнэ.

- 2.2.1. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалттай
- 2.2.2. Батлан хамгаалах болон төрийн тусгай үүрэг гүйцэтгэх зориулалттай
- 2.2.3. Байгууллагын тусгай хэрэгцээний зориулалттай
- 2.2.4. Нэг удаагийн хүнд даацын тээвэрлэлт гүйцэтгэх зориулалттай

Гурав. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

3.1. Тусгай зориулалтын авто замын ангилалд хамааруулах асуудлыг тээвэрлэж буй ачааны жин, зориулалт, тээврийн хэрэгсэлийн овор хэмжээ зэргээс хамааруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

3.2. Тусгай зориулалтын авто замын чиглэлийг Монгол улсын тусгай зориулалтын болон үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, Засгийн газрын бодлого, чиглэлтэй уялдуулан авто замын техник, эдийн засгийн үндэслэл, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал, авто замын салбарын шинжлэх ухаан техникийн зөвлөлийн санал дүгнэлт зэргийг үндэслэн авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батална.

3.3. Тусгай зориулалтын авто замын чиглэлийг тогтоосон тушаал гарсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд авто зам бариагүй тохиолдолд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтэд үндэслэн уг шийдвэрийг цуцална.

3.4. Тусгай зориулалтын авто замын чиглэлийг цуцалсан тохиолдолд тухайн чиглэлд авто зам барихаар хүсэлт гаргасан өөр төсөл санаачлагчид шилжүүлэх эрх авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хадгалагдана..

Дөрөв. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг эзэмшигчийн эрх

4.1. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг тухайн авто замын эзэмшигч тэргүүн ээлжинд ашиглах бөгөөд замын нэвтрүүлэх хүчин чадлаас хэтэрсэн хөдөлгөөний эрчим бий болоогүй нөхцөлд холбогдох шаардлага хангасан гуравдагч этгээдэд төлбөртэйгөөр ашиглуулах үүрэг хүлээнэ.

4.2. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг эзэмшигч нь төлбөр хураах нэгж ажиллуулах, тухайн авто замаар зорчих тээврийн хэрэгслээс төлбөр хураамж авах эрхтэй.

Тав. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж эзэмшигч хариуцагчын бүртгэл, бүртгэлийн хураамж, зам барилгын ажлын санхүүжилт

5.1. Тусгай зориулалтын авто замыг барьсны дараа ашиглалтад оруулахдаа Т-01-ээс эхлэн Т-02, Т-03 гэх мэтээр “Т” үсгийн ард бүхэл араб тоогоор алгасалгүй дугаарлан чиглэлийн нэр, дугаар өгч, авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

5.2. Тусгай зориулалтын авто замын чиглэлийг баталсан тушаал нь дугаарлалт олгох үндэслэл болохгүй.

5.3. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж болон түүнийг эзэмшигч, хариуцагч байгууллага, аж ахуйн нэгжийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж, гэрчилгээ олгоно.

5.4. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж болон түүнийг эзэмшигч, хариуцагчийн гэрчилгээ нь 3 жилийн хугацаатай байх бөгөөд түүнээс цааш 5 жил тутамд сунгана. Авто замын эзэмшигчийн гэрчилгээг шинээр авах үед 1 удаа гэрчилгээний төлбөр төлөх бөгөөд цаашид сунгах тутамд дахин төлбөр төлнө. Уг төлбөрөөс олсон орлогыг авто замын эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Авто замын санд төвлөрүүлнэ.

5.5. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг эзэмшигчийн гэрчилгээний төлбөр нь эзэмшиж авто замын уртаас хамаарах бөгөөд км тутамд 50000 төгрөг байна.

5.6. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих үйл ажиллагааг тусгай зориулалтын тээвэрлэлтийг үйл ажиллагаа явуулах болон хөрөнгө оруулах, авто замыг эзэмших, хариуцах байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ.

Зургаа. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах

6.1. Захиалагч нь авто замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг зохион байгуулна.

6.2. Техник, эдийн засгийн үндэслэлийг батлагдсан ажлын даалгаврын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага боловсруулна.

6.3. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж, авто замын салбарын шинжлэх ухаан, техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн тохиолдолд авто замын чиглэл батлуулахаар авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандана.

Долоо. Зураг төсөл боловсруулах

7.1. Авто замын чиглэл батлагдан, гэрээ байгуулсны дараа зураг төслийг батлагдсан зургийн даалгаврын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

7.2. Төслийн захиалагчаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн “Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар”-ыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.3. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн зураг төслийг төсөл хэрэгжүүлэгчийн хөрөнгийн эх үүсвэрээр хийж гүйцэтгэнэ.

Найм. Авто зам барих

8.1. Тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага төслийн захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

8.2. Авто замын барилгын ажлыг эхлүүлэхээс өмнө төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

8.3. Гүйцэтэгч нь “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-д заасны дагуу холбогдох байгууллагаас тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авсны дараа зам барилгын ажлыг эхлүүлнэ.

8.4. Авто замын барилгын ажлыг магадлалын дүгнэлт бүхий батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу гүйцэтгэнэ.

8.5. Авто замыг ашиглалтад авах асуудлыг холбогдох журмын дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

Ес. Зам барилгын ажлын техник, технологийн хяналт

9.1. Авто зам, замын байгууламжийн ажлын техник, технологийн хяналтыг Авто замын тухай хуулийн 21.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага /Зөвлөх/ захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

9.2. Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналт тавих ажиллагааг “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу хэрэгжүүлнэ.

9.3. Зөвлөх нь тухайн авто замыг барих явцад технологийн болон өдөр тутмын хяналтыг газар дээр гүйцэтгэн, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, гүйцэтгэлийг баталгаажуулах мэргэжлийн үйлчилгээг үзүүлнэ.

9.4. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн барилгын ажилд хяналт гүйцэтгэх Зөвлөхийг захиалагч сонгон шалгаруулна.

Арав. Замын засвар, арчлалт

10.1. Тусгай зориулалтын авто замын засвар, арчлалтын ажлыг авто замын эзэмшигч нь тус замыг эзэмших, ашиглах хугацаанд өөрийн хөрөнгөөр хариуцан гүйцэтгэж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

10.2. Замын эзэмшигч нь Авто замын тухай хуулийн 23.1-д заасны дагуу авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий зам хариуцагч байгууллагатай зохих журмын дагуу гэрээ байгуулж гүйцэтгүүлж болно.

10.3. Зам хариуцагч байгууллага нь Авто замын тухай хуулийн 23.3-д заасан үүргийг хэрэгжүүлнэ.

10.4. Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлыг холбогдох норм дүрэм, техникийн шаардлага, технологийн горимыг чанд мөрдөж гүйцэтгэнэ.

Арван нэг. Авто зам эзэмших гэрээ

11.1 Чиглэл батлагдсаны дараа Авто замын тухай хуулийн 17.4-д заасны дагуу төслийн хөрөнгө оруулагч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай уг авто замыг барих, ашиглах, шилжүүлэх нөхцөлүүдийг тусгасан гэрээ байгуулна.

11.2 Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон загвар гэрээнд холбогдох хуулийн дагуу талууд харилцан тохиролцсон нөхцөлүүдийг тусгана.

Арван хоёр. Авто замын ашиглалт, авто зам ашигласны төлбөр, хураамж, рояалти

12.1. Авто зам баригдаж дууссаны дараа комисс ажиллан ашиглалтад хүлээн авснаар тусгай зориулалтын авто замыг ашиглаж эхэлнэ.

12.2. Авто зам ашигласны төлбөр хураамжийн хэмжээг тухайн чиглэлийн авто зам, замын байгууламжийн хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэл болон зам эзэмшигч болон хэрэглэгч байгууллагын саналд үндэслэн эзэмшигчид үр ашигтай байх, хэрэглэгчид хэт дарамт учруулахгүй байх хэмжээгээр тогтоож, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санал боловруулан Засгийн газраар батлуулна.

12.3. Авто зам ашигласны төлбөр хураамжийн хэмжээг авто зам эзэмших гэрээнд тодорхой тусгах бөгөөд хэрвээ өөрчлөлт орсон тохиолдолд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад танилцуулан, Засгийн газраас холбогдох шийдвэр гаргуулна.

12.4. Авто зам эзэмшигч нь тухайн жилд хураасан авто ашигласны төлбөр хураамжийн 2%-тай тэнцэх хэмжээний рояалти төлөх бөгөөд энэ рояалтигаас олсон орлогыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Авто замын санд төвлөрүүлнэ.

12.5. Эзэмших гэрээний хугацаа дуусгавар болоход ашиглалтын бэлэн байдлын шаардлагыг хангасан байдалтайгаар авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлж өгнө.

Арван гурав. Байгаль орчны асуудал

13.1. Авто зам барих, засварлах, ашиглах үед байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлт хийх асуудлыг тухайн төсөл хэрэгжүүлэгч байгууллага хариуцна.

13.2. Төсөл хэрэгжүүлэгч нь авто замын барилгын ажлыг эхлүүлэхээс өмнө Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2-т заасны дагуу “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ”-г хийлгэнэ. Хэрэв үнэлгээгээр байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж дүгнэсэн тохиолдолд уг үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий дотоодын аж ахуйн нэгжээр хийлгэнэ.

13.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.

13.4. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний хүрээнд боловсруулсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний дагуу төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх арга хэмжээг авна.

Арван дөрөв. Замын хөдөлгөөний аюулгүй байдал

14.1. Авто замыг төлөвлөх, барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах, арчлан хамгаалах болон ашиглалтын үеийн хөдөлгөөн зохион байгуулалтыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэнэ.

Арван тав. Хариуцлага

15.1. Энэхүү журмын 14 дүгээр зүйлийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-oOo-